



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
иргэдийг элсүүлэх, албанаас халах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80, 2022 оны 279 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 44 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/469 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд 2023-2025 онд алба хаахаар хүсэлт гаргасан иргэдтэй гэрээ байгуулж, алба хаах хугацаанд, үүрэг гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, 2021-2023 онд Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж, хугацаа дууссан иргэдийг халах, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам зөрчсөн иргэдтэй гэрээг цуцлах нэрийн жагсаалтыг хоёрдугаар, Цэргийн дүйцүүлэх албанд элссэн иргэдийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай хувцас, тусгай хэрэглэлийн зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн хувцас тусгай хэрэглэлийн зардалд шаардагдах 4,160,000 (Дөрвөн сая нэг зуун жаран мянга) төгрөгийг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Санжийжамц)-д үйл ажиллагааг зохион байгуулж дууссанаас хойш 5 хоногийн дотор танилцуулж, зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД